

# ЖИЛИЙН ТАЙЛАН 2022



Бүх зүйл хүмүүсээс үүдэлтэй. Баг, хамт олон,  
бизнес, үйлчилгээний байгууллагын аль нь ч  
сэтгэлтэй, мэдрэмжтэй, эрч хүчтэй  
хүмүүсгүйгээр оршин тогтнох боломжгүй.

Бидний үнэт зүйлсээс...

# Агуулга

Эрхэм зорилго, Хэтийн зорилт.....	04
Бидний үнэт зүйлс.....	05
Байгууллагын танилцуулга.....	06
Гүйцэтгэх удирдлагын мэндчилгээ.....	08
Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл.....	10
Төлөөлөн удирдах зөвлөл.....	12
Бүтэц, зохион байгуулалт.....	14
Удирдлагын баг.....	16
Хараат бус аудитын тайлан.....	18
Санхүүгийн үзүүлэлтүүд.....	24
2022 оны онцлох үйл явдлууд.....	26
Нийгмийн хариуцлага .....	30
Технологийн инноваци.....	32
Хүний нөөцийн үйл ажиллагаа.....	36
Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ.....	38
Эрсдэлийн удирдлага.....	42
Салбар нэгжийн мэдээлэл.....	44



# Эрхэм зорилго, Хэтийн зорилт

Худалдааны салбарт түшиглэсэн дижитал банк болох



## ЭРХЭМ ЗОРИЛГО

Ухаан, Хүсэл, Уран сэтгэмж  
Улам шинэлэг хамт олноороо  
Уулзсан бүхний сэтгэлийг хөдөлгөх  
банк

## ХЭТИЙН ЗОРИЛТ

Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний  
цахим болон биет сувгийн оновчтой  
хослолоор харилцагчиддаа  
бүтээгдэхүүн үйлчилгээгээ  
хүргэдэг, харилцагчийн гайхалтай  
үйлчилгээтэй, нийгмийн  
хариуцлагаараа манлайлагч банк  
болох

# Бидний үнэт зүйлс

## ХҮМҮҮС

Сэтгэлтэй, мэдрэмжтэй,  
эрч хүчтэй

Бүх зүйл хүмүүсээс үүдэлтэй. Баг, хамт олон, бизнес, үйлчилгээний байгууллагын аль нь ч сэтгэлтэй, мэдрэмжтэй, эрч хүчтэй хүмүүсгүйгээр оршин тогтнох боломжгүй.

Тиймээс Хүмүүс бусад зүйлсийг бий болгон, нийцүүлэн зангидаж, гол Цөм нь болж байгаа юм. Манай хамт олон төрөл бүрийн мэргэжил, нас, хүйс, ажил амьдралын туршлага, үндэстний төлөөллөөс бүрддэгээр нь бахархаж бид Хүмүүсээ олон төрлийн өнгө, хэмжээ, дүрсээр билэгдлээ.

## БҮТЭЭГДЭХҮҮН

Амдуулан бодсон,  
Амьдралаас үүдсэн

Тулгуур хоёр баганын баруун багана болох "Бүтээгдэхүүн" нь бидний үйлчилгээ хүний хэрэгцээг амдуулан бодсон, асуудлыг шийдсэн, бодит амьдралаас үүдсэн байхыг илэрхийлж халуун дулаан, холоос ялгаран танигдах, эрч хүчээр дүүрэн галын Улаан өнгөөр бүтээсэн билээ.

## ҮЙЛ ЯВЦ

Шуурхай, Найдвартай, Саадгүй

Хоёр тийш жийн бат зогсох тулгуур хоёр баганын зүүн багана болох Үйл Явц нь бүтээгдэхүүн үйлчилгээг хэрхэн судлан бүтээж, эцсийн харилцагчид хэрхэн толилуулж, хүргэхийг хэлж байгаа юм. Харилцагчийн нүдээр харахад зарим зүйлсийг бид явцын дунд хэчнээн төвөгтэй болгож хувиргасныгаа тэр болгон ухаардаггүй. Тэгвэл бид Үйл Явцаа ямарваа нэгэн саад төвөггүй, ногоон гэрлээр урсгаж байхыг илэрхийлж Ногоон өнгөөр бүтээлээ.

## ОРЧИН

Зочломтгой, Тухтай, Халамжтай

Манайхаар орсон хүн зочломтгой, тухтай, халамжтай орчныг мэдрэх учиртайг Хөх Ягаан өнгөөр төлөөлүүлээ. Хөх Ягаан өнгө нь "орчин үе"-ийг илэрхийлдэг өнгө юм.



АРИГ БАНК

## Бидний тухай

26 жилийн түүхтэй Ариг банк нь анх 1997 онд “Эрэл банк” нэртэйгээр үүсгэн байгуулагдсан. 2014 онд нэр, өнгө төрхөө шинэчилж байгууллагын нэрээ цэвэр, тунгалаг гэдэг утга агуулгатайгаар “Ариг Банк” хэмээн өөрчилж, шинэ бодлого, шинэ өнгө төрхөөр харилцагч нартаа хүрч үйлчилж эхэлсэн.

НИЙТ ХАРИЛЦАГЧИЙН ТОО	ХАРИЛЦАХ ДАНС ЭЗЭМШИГЧ	ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧ
54,154	38,027	16,112
ИНТЕРНЭТ БАНК ХЭРЭГЛЭГЧ	КАРТ ЭЗЭМШИГЧ	ПОС ЭЗЭМШИГЧ
21,120	3,000	504
САЛБАР, ТООЦООНЫ ТӨВ	НИЙТ АЖИЛТНЫ ТОО	ЗЭЭЛДЭГЧИЙН ТОО
12	211	2614

# Гүйцэтгэх удирдлагын мэндчилгээ

## Хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид, түншүүд, хамтран ажиллагсад аа,

Монгол Улсын банк санхүүгийн зах зээлд 26 дах жилдээ үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж буй Ариг банкны 2022 онд та бүхэнтэй хамтран хийж бүтээсэн ажлынхаа үр дүнг танилцуулж байна. 2022 он дэлхий нийтээр шинэ сэргэлтийн жил байснаас гадна геополитикийн хувьд ихээхэн анхаарал татахуйц үйл явдлууд өрнөсөн, макро орчны нөлөөлөл бүхий л улс орнуудад хүндхэн туссанаас үүдэн төв банкнууд бодлогын хүүгээ өсгөсөн, эдийн засгаа сэргээхэд ихээхэн хүчин чармайлт шаардсан жил болж өнгөрлөө. Монгол улсын хувьд жилийн эхний хагаст эдийн засгийн хүндхэн сорилтуудыг давж, оны сүүлээр гадаад худалдааны эргэлт сэргэн, эрчимтэй өсөөд байсан инфляц тогтворжих төлөвтэй байсан ч Орос-Украины дайны хурцадмал байдал нь эдийн засаг, банк санхүүгийн салбарт хүндхэн шалгуур, сорилтыг бий болгосон жил байлаа.

Эдийн засаг, санхүүгийн энэхүү эгзэгтэй агшинд банк санхүүгийн зах зээлд тухайн мэргэжлээрээ тодорхой хугацаанд шалгагдан ажилласан удирдах түвшний болон мэргэшсэн ажилтнуудаас бүрдсэн Ариг банкны шинэ менежментийн баг оновчтой зөв шийдвэрүүдийг цаг алдалгүй гаргаж, ажилтнуудынхаа хүчин чармайлт, харилцагчдынхаа дэмжлэгтэйгээр тулгарсан сорилтыг амжилттай даван туулж, үйл ажиллагаагаа тэлэн олон өөрчлөлт шинэчлэлт, ахиц дэвшлийг хамтдаа бүтээлцсэнээр 2022 онд Ариг банкны санхүүгийн үзүүлэлт өмнөх онтой харьцуулахад нийт актив 153 хувиар өсөж 260.4 тэрбум төгрөгт, нийт цэвэр зээлийн үлдэгдэл 471 хувиар өсөж 94.5 тэрбум төгрөгт, нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 150.6 хувиар өсөж 163.7 тэрбум төгрөгт хүрч, 8.2 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан үр дүнд хүрсэн.

Өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй харилцагчдынхаа хүсэл сонирхолд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгон хүргэх, дижитал эринд нийцүүлэн ажиллахад ихээхэн анхаарч байна. Үүний үр дүнд банкны



салбарт дижитал банкны хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг илүү таниулсан Arig Online аппликэйшн бүтээж, шинэ оны босгон дээр зах зээлд нэвтрүүлснээр 19,360 харилцагчийн санхүүгийн өдөр тутмын хэрэглээ болгож чадсан юм. Мөн банкны үндсэн системдээ NES программыг нэвтрүүлснээр банкны үйлчилгээг илүү найдвартай, хурдан шуурхай, хялбар аргаар үзүүлэх нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн. Эдийн засгийн бодит нөхцөл байдлаас үүдэн Монгол улсад бүх төрлийн зээлийн үйл ажиллагаа хумигдсан үед, мөн Монголбанкнаас Ариг банкны үйл ажиллагаанд тавигдсан хязгаарлалтууд чөлөөлөгдөхтэй зэрэгцэн бид харилцагчдынхаа шаардлагад тулгуурлан бүх төрлийн зээлийг олгосноор эдийн засгийн эргэлтийг хэвийн түвшинд хадгалж үлдэхэд хувь нэмрээ оруулж, хадгаламж болон зээлийн 12 гаруй төрлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүллээ.

Ариг банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл банкны стратегийг оновчтой тодорхойлох идэвх зүтгэл гарган ажиллаж банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Монголбанкнаас тавьсан хуулийн шаардлагын дагуу 100 тэрбум төгрөгт хүргэснийг тусгайлан тэмдэглэж байна.

Бид 2022 онд хийж бүтээсэн ажлынхаа эрч хүчийг хадгалах, дунд хугацааны стратегийн батлагдсан төлөвлөгөөгөө бүрэн хэрэгжүүлэх, цаашлаад Монгол улсын банк санхүүгийн зах зээлд эзлэх байр сууриа өргөжүүлж, нэмэгдүүлэхдээ цахим технологид суурилсан дижитал банкны үйл ажиллагааг бий болгохыг зорин ажиллах болно.

Бид Санхүү тайлагналын олон улсын стандарт (СТОУС) 9 “Санхүүгийн хэрэглүүр”-ийг амжилттай нэвтрүүлж, банкныхаа санхүүгийн байдал, жилийн санхүүгийн гүйцэтгэлийг олон улсад нэр хүнд бүхий “BDO LLC” аудитын компаниар баталгаажуулж, Санхүү тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн дүгнэлт бүхий иж бүрэн тайланг Та бүхэндээ хүргэж буйдаа сэтгэл дүүрэн байна.

Ариг банкны гүйцэтгэх удирдлагын баг, банкныхаа ирээдүйн төлөө өөрийн мэдлэг туршлага, ур чадвараа дайчлан ажиллаж буй хамт олон, бидэнд өндөр итгэл хүлээлгэн хамтран ажилладаг харилцагч, үйлчлүүлэгч, түнш байгууллагууд болон бидний хийж хэрэгжүүлэх ажлыг оновчтой чиглэл тодорхой шийдвэрээр дэмжин ажилладаг Төлөөн Удирдах Зөвлөл, хувь нийлүүлэгч, хөрөнгө оруулагч та бүхэндээ талархаж байна

Хүндэтгэсэн,

О. Хүрэлбаатар

Ариг банкны Гүйцэтгэх захирал

# Хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл

## 78.84%


### УЛААНБААТАР ИМПЕКС ХХК

“Ариг Банк” ХХК-ийн толгой компани ба банк, санхүүгийн салбарт хөрөнгө оруулахад төвлөрч ажиллаж байна. Ариг банкны энгийн хувьцааны 78.84 хувийг эзэмшигч компани юм. Тус компанийн 73.18 хувийг иргэн Ш.Баярсайхан, 26.82 хувийг “Номин реалтор” ХХК эзэмшдэг.

## 21.16%

### ДЭМ САНХҮҮГИЙН НЭГДЭЛ

“Ариг Банк” ХХК-ийн толгой компани бөгөөд банк, санхүүгийн салбарт голлонтөвлөрч ажилладаг. Ариг банкны энгийн хувьцааны 21.16 хувийг эзэмшигч компани юм. Тус компанийн 100%-ийн хувьцааг иргэн Б.Эрдэнэбат эзэмшдэг.



# Төлөөлөн удирдах зөвлөл



**Пүрэвийн  
МӨНХ-ЭРДЭНЭ**

ТУЗ-ийн дарга, хараат  
бус гишүүн



**Санжаагийн  
САЙНБАТ**

ТУЗ-ийн гишүүн



**Шагдарсүрэнгийн  
БАЯРСАЙХАН**

ТУЗ-ийн гишүүн



**Сэнгэдоржийн  
ХОСБАЯР**

ТУЗ-ийн гишүүн



**Дэлэгийн  
ТҮВШИНТАМИР**

ТУЗ-ийн хараат бус  
гишүүн



**Ганбатын  
ТЭМҮҮЖИН**

ТУЗ-ийн дэргэдэх  
Дотоод аудитын газрын  
захирал

## Төлөөлөн удирдах зөвлөл

### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Ариг Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөл /ТУЗ/ нь “Банкны тухай хууль”, “Компанийн тухай хууль”, “Ариг Банкны дүрэм” болон “ТУЗ-ийн үйл ажиллагааны журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон журам тогтоомж, дүрмээр олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ажил үүргээ хариуцлагатай биелүүлж ажиллахыг чиглэлээ болгодог.

ТУЗ-ийн үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх, үүрэг зэрэг нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журмаар зохицуулагдах бөгөөд хуульд заасны дагуу ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн Дарга зарлаж хуралдуулна. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудал, хэрхэн шийдвэрлэсэн тухай тэмдэглэлийг хөтлөн, гарын үсгээр баталгаажуулж хуульд заасан хугацаанд хувьцаа эзэмшигч нар болон Монголбанкинд хүргүүлэн ажилладаг. Компанийн тухай хуульд заасан их хэмжээний хэлцэл, сонирхлын зөрчилтэй хэлцэл зэрэгт холбогдох хороод нь эрх, үүргийн дагуу хяналт тавин ажилладаг болно.

ТУЗ нь банкны үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллахаар зохион байгуулагдсан бөгөөд ТУЗ-ийн гишүүдийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх эрхийг банкны Хувьцаа эзэмшигч нар эдэлнэ /Хараат бус гишүүнийг Монголбанкны зөвшөөрснөөр Хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэнэ/

### ЭРСДЭЛИЙН УДИРДАГЫН ХОРОО

Банкны зээлийн, зах зээлийн, хөрвөх чадварын, үйл ажиллагааны, хууль эрх зүйн, нэр хүндийн, мэдээлэл технологийн болон бусад төрлийн эрсдэлийн удирдлагын талаар авч буй арга хэмжээ

нь хангалттай байгаа эсэхэд хяналт тавин ажиллах үүрэгтэй бөгөөд журмын хэрэгжилтийг жил болгон хянаж, ТУЗ-д зохистой өөрчлөлт оруулах талаар санал гарган ажиллана.

### АУДИТЫН ХОРОО

Банкны санхүүгийн үнэн зөв, бүрэн бүтэн тайлагнал, банканд хийгдэх дотоод болон хөндлөнгийн аудитаар ажиллах аудиторудын үйл ажиллагааг хянах, ТУЗ болон Хувьцаа эзэмшигчид нэрсийг санал болгох, сонгон шалгаруулах, цалин урамшуулал олгох, ажлаас чөлөөлөх, аудитын хүрээ, давтамжийг тогтоох, тайлантай танилцах, аудитын дүгнэлтэд дурдсан банкны дотоод хяналтын тогтолцооны сул талууд, цаашид авах арга хэмжээний талаарх саналыг Гүйцэтгэх удирдлага нь хууль тогтоомжийн дагуу тохиромжтой цаг хугацаанд хэрэгжүүлж буй эсэхэд хяналт тавин ажиллах үүрэгтэй.


### ХҮНИЙ НӨӨЦ, ЦАЛИН, УРАМШУУЛЛЫН ХОРОО

ТУЗ хяналт, удирдлагын үүргээ үр дүнтэй, банканд үр ашигтай гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхээр байгуулагдсан бөгөөд банкны цалин урамшууллын бодлого, практикт нь чадварлаг ажилтан, менежерийг ажилд авах, улмаар тогтвор суурьшилтай ажиллуулах, урамшуулан хөгжүүлэх замаар банкны бизнесийн зорилтдоо хүрэх, тогтвортой бизнесийн хөгжил авчрахад дэмжлэг үзүүлэх үүрэгтэй.

### АУДИТЫН ГАЗАР

Банкны тоон болон чанарын үзүүлэлтүүд дээр үндэслэн одоо байгаа болон цаашид үүсэж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, түүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийн төвшин тогтоох, эрсдэлтэй цэг болон газар дээрх шалгалтын хэрэгцээг тодорхойлж ажиллана. Банкны үйл ажиллагаанд газар дээр нь хийх шалгалтын төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулан, үр дүнг ТУЗ-д танилцуулан, шаардлагатай арга хэмжээг авч, зөвлөмжийг өгч ажиллана.

# Бүтэц, зохион байгуулалт





# Удирдлагын баг



**О.Хүрэлбаатар**

Гүйцэтгэх захирал



**Б.Бямбаноров**

Бизнес хариуцсан  
Дэд захирал

**Ш.Энхтөр**

Захиргаа, эрх зүйн  
газрын захирал



**Х.Анхсүрэн**

Бизнес банкны  
газрын захирал

**Э.Ананд**

Санхүү удирдлагын  
газрын захирал



**Б.Оюунцэцэг**

Бизнес хөгжлийн  
газрын захирал

**М.Санчир**

Хөрөнгө зохицуулалтын  
газрын захирал

**Б.Мандуул**

Дижитал банкны  
газрын захирал



**Т.Ган-Эрдэнэ**

Эрсдэлийн удирдлагын  
газрын захирал

**А.Тамир**

Мэдээлэл технологийн  
газрын захирал

**Ж.Мөнх-Итгэлт**

Дотоод хяналтын  
газрын захирал

# Хараат бус аудиторын тайлан

## АРИГ БАНКНЫ 2022 ОНЫ 12-Р САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Ариг банк нь 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөрх Аудитлагдсан санхүүгийн тайлангаа танилцуулж байна.

2022 онд Ариг банкны нийт актив 260.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны үзүүлэлтээс 153 хувиар өссөн ба үүнд харилцагчдын харилцах, хадгаламж 80 хувь, Түргэн борлогдох актив 148 хувь, зээлийн багц 470 хувь өсөж, нийт актив 157.7 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээр 7.6 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, өөрийн хөрөнгийн өгөөж 5.8 хувьд хүрлээ.

Өнгөрсөн жилийн хугацаанд Ариг банк нь өдрөөс өдөрт нэмэгдэж буй харилцагчдынхаа хүсэл сонирхолд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлж олон төрлийн үйлчилгээг санал болголоо. Мөн дижитал банкны хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг илүү таниулж Arig Online аппликэйшнээ хүргэснээс гадна, банкны үндсэн системдээ NES программыг амжилттай нэвтрүүллээ. Итгэлтэй найдвартай байдлаа бататган цар хүрээгээ тэлсэнээс гадна хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг Монгол банкны шалгуурт нийцүүлэн 100 тэрбум төгрөгт хүргэсэн зэрэг амжилттай нэг жилийг үдлээ.

# Хараат бус аудиторын тайлан



АРИГ БАНК

Албан Тооц № 5-13/268

Огноо: 2023.04.12

Хуучбарыг: \_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

## УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

Банкны удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Ариг Банк ХХК (цаашид “Банк” гэх)-ийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэгдсэн болно. Банкны удирдлага 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайланг жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлж тайлагнасан болохыг баталгаажуулах үүрэгтэй.

Банкны удирдлага нь Банкны санхүүгийн тайланг тодруулга 2-т дурдсан шаардлагуудад нийцсэнийг баталгаажуулах боломжийг бүрдүүлж, санхүүгийн байдлыг үндэслэлтэй, үнэн зөвөөр илэрхийлэх зөв зохистой нягтлан бодох бүртгэлийг хөтөлж бэлтгэсэн гэдгийг баталгаажуулах үүрэгтэй.

Мөн удирдлага нь Банкны эд хөрөнгийг хадгалан хамгаалах, аливаа залилан, зүй бус үйлдлээс сэргийлэх, ийм үйлдэл гарвал илрүүлэхэд шаардлагатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

Банкны удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлогыг сонгон, тууштайгаар даган мөрдөж, үндэслэлтэй, нягт нямбай тооцоолол, үнэлгээ хийн, холбогдох бүх нягтлан бодох бүртгэлийн стандартыг мөрдсөн гэж үзэж байна.

Банкны удирдлагаас Ариг Банк ХХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайланг зөвшөөрч батлав.

ОСОРДЭЛЭГ ХҮРЭЛБААТАР

Гүйцэтгэх захирал

ЭНХБАТ АНАНД

Санхүү хариуцсан захирал

Монгол Улс,  
Улаанбаатар хот  
2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр

Чангасгийн Өргөн Чөлөө  
Хан-Уул дүүрэг  
Улаанбаатар хот 17030  
Монгол Улс

Байгууллагын шугам:  
7012 2222  
И-мэйл: info@arigbank.mn  
Вэб: www.arigbank.mn

Лавлах нөв:  
7013 3060

00001970

# Хараат бус аудиторын тайлан

# Хараат бус аудиторын тайлан



Tel: +976 77404040  
Fax: +976 77404041  
www.bdo.mn  
Zip code: 13110

Room: 1502, Level 15  
Union Building - B, Paris Street  
Narain Zam - 62, Khoroo - 1  
Sukhbaatar District, Ulaanbaatar  
Mongolia

Утас: +976 77404040  
Факс: +976 77404041  
www.bdo.mn  
ШНХ: 13110

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
1-р хороо, Нарны зам - 62, Парисын  
гудамж, ЮНИОН БИУДИНГ Б Блок  
15-р давхар, 1502 тоот

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Ариг Банк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд

### Санал дүгнэлт

Ариг Банк ХХК ("Банк")-ийн дараах тайлангуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2022 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийн томоохон бодлогуудын хураангуйг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт ("АОУС")-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НБЭЗОУСЗ")-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм (Хараат бус Байдлын Олон Улсын Стандартын багтаасан) болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу банкнаас хараат бус байсан бөгөөд НБЭЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

### Бусад асуудлууд

Банкны 2021 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болсон санхүүгийн тайланд өөр аудитор аудит хийсэн бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын тайланд өөрчлөлтгүй дүгнэлт илэрхийлж 2022 оны 03 сарын 15-ны өдөр гарын үсэг зурсан.

### Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм үү заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь компанийг татан буулгах юм үү үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн тасралтгүй байх зарчим ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the international BDO network of independent member firms.  
Монгол Улсын хягаарлагдмал хариуцлагатай компани болох БДО АУДИТ ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн, олон улсын БДО сүлжээний бие даасан гишүүн байгууллагуудын нэг юм.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй. Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн үг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.
- Мөн олж авсан аудитын нотолгоо дээр үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг тасралтгүй үйл ажиллагаа үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил, дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.



КУРШИД АЛАМ  
БДО Аудит ХХК  
1502 тоот, 15-р давхар, Юнион Биудинг, Б Блок  
Парисын Гудамж, Нарны зам-62,  
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо  
Улаанбаатар хот, Монгол улс

Огноо: 2023.04.12

BDO AUDIT LLC, a Mongolian Limited Liability Company, is a member of BDO International Limited, a UK company limited by guarantee, and forms part of the international BDO network of independent member firms.  
Монгол Улсын хягаарлагдмал хариуцлагатай компани болох БДО АУДИТ ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн, олон улсын БДО сүлжээний бие даасан гишүүн байгууллагуудын нэг юм.

# Хараат бус аудиторын тайлан

## АРИГ БАНК ХХК

### Санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

	Тодруулга	2022	2021 Дахин тайлагнасан*
Үр ашигт хүүгийн аргаар тооцсон хүүгийн орлого	3	13,502,844	4,852,694
Бусад хүү болон түүнтэй адилтгах бусад хүүгийн орлого	3	1,835,446	1,610,648
Хүү болон түүнтэй адилтгах зардал	4	(3,867,460)	(2,703,166)
<b>Хүүгийн цэвэр орлого</b>		<b>11,470,830</b>	<b>3,760,176</b>
Хураамж ба шимтгэлийн орлого	5	419,452	313,001
Хураамж ба шимтгэлийн зардал	5	(244,529)	(256,220)
<b>Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого</b>		<b>174,923</b>	<b>56,781</b>
Арилжааны цэвэр орлого /зардал	6	4,673,462	363,304
ААБҮЦ-ээр хэмжигдэх бусад санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлого/(зардал)	7	27,936	(123,467)
<b>Үйл ажиллагааны нийт орлого</b>		<b>16,347,151</b>	<b>4,056,794</b>
Бусад орлого	8	348,295	418,341
Санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнийн бууралтын олз	11	3,381,153	(381,100)
Үүний нөөцийн зардал	9	(5,616,683)	(2,998,420)
Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал	17	(568,452)	(571,375)
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийн зардал	17	(623,248)	(234,468)
Биет бусад хөрөнгийн элэгдлийн зардал	18	(178,873)	(173,981)
Бусад зардал	8	(3,905,854)	(4,100,135)
Үйл ажиллагааны бус зардал	10	(113,827)	(95,732)
<b>Татварын өмнөх ашиг/(алдагдал)</b>		<b>9,069,662</b>	<b>(4,080,076)</b>
Орлогын албан татварын зардал	12	(885,970)	357,569
<b>Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)</b>		<b>8,183,692</b>	<b>(3,722,507)</b>
<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>			
<b>Тодорхой шалгуур хангасан тохиолдолд ашиг, алдагдал руу шилжих бусад дэлгэрэнгүй орлого</b>			
Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлт		-	-
<b>Тайлант жилийн дэлгэрэнгүй ашиг/(алдагдал)</b>		<b>8,183,692</b>	<b>(3,722,507)</b>

\*СТОУС 9-ийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дахин тайлагнал хийсэн ба дэлгэрэнгүй тодруулгыг 2.4-аас харна уу.

Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

# Хараат бус аудиторын тайлан

## АРИГ БАНК ХХК

### Санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн


(Мянган төгрөгөөр)	Тодруулга	2022.12.31	2021.12.31 Дахин тайлагнасан*	2021.01.01 Дахин тайлагнасан*
<b>Хөрөнгө</b>				
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	13	48,255,697	11,569,405	18,448,727
Бусад банк, санхүүгийн байгууллага дахь харилцах, хадгаламж	14	97,805,509	59,909,220	4,589,130
ААБҮЦ-ээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	15	4,402,477	4,397,477	2,867,460
БДОБҮЦ-ээр илэрхийлэгдэх санхүүгийн хөрөнгө	15	923,941	33,744	33,744
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	16	101,358,715	24,748,927	30,329,309
Үндсэн хөрөнгө	17	7,807,915	2,735,211	2,905,037
Биет бус хөрөнгө	18	1,118,111	483,752	602,297
Хойшлогдсон татварын хөрөнгө	12	1,325,653	1,659,454	1,298,657
Бусад хөрөнгө	19	3,443,942	2,441,680	5,060,296
<b>Нийт хөрөнгө</b>		<b>266,441,960</b>	<b>107,978,870</b>	<b>66,134,657</b>
<b>Эздийн өмч ба өр төлбөр</b>				
<b>Өр төлбөр</b>				
Банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	20	90,643,376	25,538,051	41,771
Харилцагчдын харилцах, хадгаламж	21	61,872,129	34,428,837	29,533,990
Зээлээр авсан санхүүжилт	22	11,488,147	6,045,365	6,001,084
Орлогын албан татварын өглөг	12	164,232	16,323	33,122
Хойшлогдсон татварын өглөг	12	40,909	6,121	2,893
Бусад өр төлбөр	23	2,964,223	875,516	737,728
<b>Нийт өр төлбөр</b>		<b>167,173,016</b>	<b>66,910,213</b>	<b>36,350,588</b>
<b>Эздийн өмч</b>				
Энгийн хувьцаа	24	100,033,190	50,016,595	35,009,500
Бусад нөөц		3,041	3,041	3,041
Тусгай зориулалтын нөөц		7,106,769	6,782,219	4,974,376
Хуримтлагдсан ашиг / алдагдал		(7,874,056)	(15,733,198)	(10,202,848)
<b>Нийт эздийн өмч</b>		<b>99,268,944</b>	<b>41,068,657</b>	<b>29,784,069</b>
<b>Нийт эздийн өмч ба өр төлбөр</b>		<b>266,441,960</b>	<b>107,978,870</b>	<b>66,134,657</b>

СТОУС 9-ийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор дахин тайлагнал хийсэн ба дэлгэрэнгүй тодруулгыг 2.4-өөс харна уу.


Хавсаргасан тодруулга нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

## 2022.12.31-ний байдлаарх санхүүгийн үзүүлэлтүүд

НИЙТ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ




ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАР




## 2022.12.31-ний байдлаарх санхүүгийн үзүүлэлтүүд


НИЙТ ХӨРӨНГӨ  
(тэрбум төгрөг)




ЦЭВЭР ЗЭЭЛ  
(тэрбум төгрөг)




ХАРИЛЦАХ, ХАДГАЛАМЖ  
(тэрбум төгрөг)




ӨӨРИЙН ХӨРӨНГӨ  
(тэрбум төгрөг)



ЦЭВЭР ХҮҮГИЙН ОРЛОГО  
(тэрбум төгрөг)




ЦЭВЭР АШИГ АЛДАГДАЛ  
(тэрбум төгрөг)




# 2022 ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД





25 Жил



100 тэрбум



Номин  
Бизнес карт

Санхүүгийн зах зээлд эзлэх байр сууриа тэлж, технологид суурилсан дижитал банк болохыг зорьж буй Ариг банкны 25 жилийн түүхэн ой 2022 онд тохиолоо.

Ариг банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ Монголбанкны тавьсан зорилтот хэмжээнд хүрч ₮100 тэрбум болсон. Ингэснээр эрсдэл даах чадвар нэмэгдсэнээс гадна төлбөрийн чадвар ахисан хэрэг юм.

“НОМИН ТАВ ТРЕЙД” ХХК болон “АРИГ БАНК”- ийн үнэнч харилцагчдад зориулсан лоялти үйлчилгээг цогцоор нь авах боломжтой “НОМИН БИЗНЕС КАРТ”-ыг нэвтрүүлээ. Энэхүү карт нь харилцагчийн бизнесийн өдөр тутмын үйл ажиллагаанд бодит дэмжлэг болох хөнгөлөлт, урамшуулал, шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг түрүүлж авах эрхийг багтаасан дэвшилтэт төлбөрийн хэрэгсэл юм.




Хадгаламжийн хүүгээ гурван удаа өсгөж энгийн хугацаатай хадгаламжийн жилийн хүү 13.5% боллоо.


Зах зээлд өрсөлдөхүйц банкны бүхий л үйлчилгээг амар хялбараар зайнаас авах боломжтойгоос гадна цахимаар авах үйлчилгээг тэлсэн Arig Online цахим банкны аппликэйшнээ гаргав.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” аяны хүрээнд жил бүр уламжлал болон явагддаг мод тарих үйл ажиллагаанд Ариг банк идэвхтэй оролцлоо.

Харилцагчдын эрэлт хэрэгцээг судлан тэдэнд хэрэгцээтэй байгаа банкны бүтээгдэхүүнийг олж илрүүлэн өнгөрсөн онд зээлийн 7, хадгаламжийн 5 шинэ бүтээгдэхүүнийг зах зээлд гаргалаа.




Хүү өслөө



Arig Online app



Тэрбум Мод



Шинэ Бүтээгдэхүүн

# Нийгмийн хариуцлагын ажил



**Ариг банк нь нийгмийн хариуцлага болон харилцагчдадаа үзүүлэх үйлчилгээг улам сайжруулах зорилгоор хамтын ажиллагаагаа өргөжүүлсээр байна.**

- Нийслэлийн жижиг дунд үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих төвтэй хамтран ажиллахаар болов.
- АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн санхүүжилттэй “Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх” (BEST) хөтөлбөрийг хэрэгжүүлэгч Хөгжлийн Шийдэл ТББ-тай хамтран ажиллах санамж бичиг байгуулав.
- МОСТ Финтек ХХК-тай хамтын ажиллагааны гэрээ байгууллаа.



1. Нийгмийн хариуцлагын хүрээнд жил бүр “Ахиллис Монгол” байгууллагатай хамтран ерөнхий ивээн тэтгэгчээр оролцдог Итгэл, Найдвар, Боломж бүх нийтийн марафоныг зохион байгууллаа.
2. Банкны ажилтны өдөр”-ийг угтан нийгмийн хариуцлагын хүрээнд Богд ууланд 700 ширхэг шинэс модны суулгац тарьж төгөл байгууллаа. Жил бүрийн 6 дугаар сарын 2-ны өдөр банкны салбарын хэмжээнд “Банкны ажилтны өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэ хүрээнд мод тарих

үйл ажиллагааг зохион байгуулж тогтвортой, зөв хөгжилд олон нийтийг уриалсаар ирсэн билээ.

3. Монгол улсын цус цусан бүтээгдэхүүний нөөцийг хэвийн байлгах нь нэн чухал бөгөөд үүнд цусны донорууд хамгийн чухал үүрэг оролцоотой байдаг. Тиймээс нийгмийн хариуцлагыг эрхэмлэгч Ариг банкны хамт олон Цус Сэлбэлт Судлалын Үндэсний Төвтэй хамтран “Цусаа хандивлах өдөр”-ийг зохион байгууллаа.





“  
Бид хэрэглэгчдийнхээ тав тухтай, бүтээмж өндөртэй, аюулгүй байдлыг тэргүүн эгнээнд тавин ажилладаг билээ.”

## Технологи инноваци

### NES системийг нэвтрүүлээ

2021 онд банкны бүтэц, зохион байгуулалтад шинэчлэлт хийгдэж Мэдээлэл технологийн газрын харьяанд Үндсэн системийн хэлтэс, Программ хөгжүүлэлтийн хэлтэс, Дэд бүтцийн хэлтэс гэсэн нэгжүүдийг бий болгосон. Ингэснээр газрын үйл ажиллагаа төрөлжих, ажил үүргийг гүйцэтгэх хурд нэмэгдэх, давхар болон дараалласан хяналт сайжрах нөхцөл бүрдсэн.

2022 онд банкны дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд тусгасны дагуу банкны үндсэн системийг шинэчлэх төсөл дээр илүү анхаарч ажилласан бөгөөд энэ шинэчлэлтийг дагаж хийгдэх дэд системүүдийн шинэчлэлтийг 2 үе шатанд хуваан гүйцэтгэсэн. Мөн төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох системүүдийн хөгжүүлэлтийг хийж, бизнес нэгжүүдэд хүлээлгэн өгөх, ашиглалтад оруулж ажилласан.

### Зохицуулагч байгууллагын шаардлага

Монголбанкнаас баталсан “Банкны мэдээллийн технологийн шалгуур үзүүлэлтийн журам”-ын дагуу 2019-2021 оныг хамарсан COBIT тогтолцооны хөндлөнгийн аудитыг шаардлагын дагуу хийлгэж тайланг Монголбанкинд хүргүүлсэн. Мөн Монголбанкнаас зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн тайлангийн боловсруулалт, хүргэлтийг автоматжуулах зорилгоор их өгөгдлийн технологид суурилсан Staging Big Data төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд МТГ-аас уг төсөлд идэвхтэй оролцон ажиллаж байна.

### Системийн шинэчлэлт, хөгжүүлэлт

Техник, технологийн хөгжил, шинэчлэлт нь хурдацтай явагдаж буй энэ үед олон улсын стандарт, шаардлагыг хангасан NES системийг нэвтрүүлэх төслийг банкны стратеги төлөвлөгөөнд оруулсан. Аливаа технологи, системийн нэвтрүүлэлт, шинэчлэлт нь банкны үндсэн системээс шууд хамааралтай байдаг. Тухайлбал картын систем, интернэт банк, мобайл банк, мэдээлэл солилцох систем, дотоод үйл ажиллагааны систем зэрэг зохицуулалтын болон бизнесийн зориулалттай бүх дэд системүүд нь үндсэн системтэй уялдаж ажилладаг бөгөөд үндсэн системийг өөрчлөх төслийн хүрээгд эдгээр дэд системүүдийг мөн шилжүүлэх ажлууд зэрэг хийгдсэн. Үүнд Монголбанктай холбоотой 2, төрийн байгууллагууд


холбоотой 4, банкны бизнесийн үйл ажиллагаатай холбоотой 23 дэд систем шилжсэн байна.

NES системийг нэвтрүүлснээр өмнө ашиглагдаж байсан гар ажиллагаа бүхий бизнесийн болон дотоод үйл ажиллагааны системүүд ашиглалтаас гарч үндсэн систем дэх модулиар дамжин бүрэн автомат болсон. Дижитал банкны газар хамтран мобайл банкны системийг бүрэн шинэчилж Мостмони шийдлийг банканд нэвтрүүлсэн бөгөөд бусад дэд системүүдтэй холбох хөгжүүлэлтийг ажлыг амжилттай гүйцэтгэлээ.

### Дэд бүтэц

Банкны үйл ажиллагаа нь техник, технологи, программ хангамж ашиглан явагддаг бөгөөд тэдгээрийн найдвартай ажиллагаа, тасралтгүй ажиллагаа, найдвартай байдлыг хангах нь МТГ-ын бас нэгэн чиг үүрэг байдаг. Энэ үүргийн дагуу банкны сервер компьютеруудыг албан ёсны лицензээр идэвхжүүлэх, виртуал серверүүдийг зохион байгуулдаг VMware системийн лицензийг мөн худалдан авч дэд бүтцийг бэхжүүлсэн.

Банкны үйл ажиллагаа нь техникийн хурд хүчнээс хамаарах бөгөөд энэ онд 100 ажилтны компьютерийг шинэчлэх, сервер компьютерын шинэчлэлт, сүлжээний төхөөрөмжүүдийн шинэчлэлтийг хийсэн. Ингэснээр сүлжээний тасралтгүй байдал нэмэгдэх, ажилтнуудын хурд нэмэгдэх, системийн боловсруулах чадвар сайжирсан.



# ДИЖИТАЛ БАНК



Худалдааны салбарт түшиглэсэн дижитал банк болох зорилтын хүрээнд харилцагчдын цагийг хэмнэсэн, технологийн дэвшилд тулгуурласан олон төрлийн цахим бүтээгдэхүүнийг гаргалаа.



## Төлбөрийн карт:

- Дотоодын ₮ карт болон байгууллагуудтай хамтарсан картыг шинэ дизайн, шинэ үйлчилгээний нөхцөлтэйгөөр зах зээлд гаргаж эхлэв.
- Байгууллагын бизнес дебит, кредит карт
- Visa кредит олон улсын эрхтэй карт



- Төлбөрийн картыг эрсдэлээс хамгаалах "VISA RISK MANAGER" программыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэв.

## Пос терминал:

Посын үйлчилгээндээ Андроид үйлдлийн системтэй төхөөрөмжийг шинээр нэвтрүүлж үйл ажиллагаагаа тэлсээр байна. НӨАТ-н баримт хэвлэх боломжтой Пос терминалын үйлчилгээ.

## Интернэт банк:

Харилцагчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, зах зээлд өрсөлдөхүйц "АРИГ ОНЛАЙН" цахим банкны аппликейшнийг зах зээлд шинээр гаргав. Харилцагч Ариг онлайн аппликейшнийг ашиглан дараах үйлчилгээнүүдийг хамгийн хямдаар, хялбараар гүйцэтгэх боломжтой юм. Үүнд:

- Бүх төрлийн шилжүүлэг
- Зээл
- Төлбөр төлөлт
- Гааль, татвар
- QR төлбөр тооцоо
- Бэлэн мөнгө авах
- E-shop үйлчилгээ

# Хүний нөөцийн үйл ажиллагаа

Бүх зүйл хүмүүсээс үүдэлтэй.

Баг, хамт олон, бизнес, үйлчилгээний байгууллагын аль нь ч сэтгэлтэй, мэдрэмжтэй, эрч хүчтэй хүмүүсгүйгээр оршин тогтнох боломжгүй.

Бидний үнэт зүйлсээс...

Ариг банк нь тайлан хугацаанд 210 гаран ажилтантай ажилласнаас 40%-ийг эрэгтэй, 60%-ийг эмэгтэй ажилтнууд эзэлж, нийт ажилтнуудын дундаж нас 35 байна.


Банкны үйл ажиллагааг тасралтгүй хангах үүднээс шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх ажлын хүрээнд 100 ажилтныг сонгон шалгаруулан ажлын байраар хангахаас гадна ажилтнуудынхаа карьер хөгжлийн дагуу 10 гаруй ажилтныг албан тушаал дэвшүүлэн ажлуулсныг дурдахад таатай байна.

Ажилтнуудыг хөгжүүлэх сургалтуудыг цахимаар болон танхимаар зохион байгуулан дотоодын болон гадны 65 орчим удаагийн сургалтад давхардсан тоогоор 855 орчим ажилтнуудыг хамрууллаа. Мөн тайлант хугацаанд хамт олноо ажил үйлсээрээ манлайлан ажилласан ажилтнуудыг Монголбанк болон Сангийн яамны шагналаар шагнаж урамшуулахын сацуу байгууллагын ахмад настнууддаа Сар шинийн баяр болон Ахмадын баяраар уламжлал ёсоор хүндэтгэл үзүүллээ.

Мөн бүх ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх бүрэн үзлэгт хамрууллаа.



# Шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ



Өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй харилцагчдынхаа эрэлт хэрэгцээнд нийцүүлэн орчин үеийн техник технологийн дэвшилд тулгуурлан тайлант онд дараах шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлээ.

## ЗЭЭЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮН

### ПОС-ын орлого барьцаалсан зээл

Ариг банкны ПОС төхөөрөмжийг ашигладаг иргэн, байгууллагууд ирээдүйн ПОС-ын орлогоо барьцаалан авах боломжтой зээл юм.

### Бизнесийн бичил зээл

Бизнесийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх гэнэтийн хэрэгцээ шаардлага тулгарсан тохиолдолд хөдлөх хөрөнгө /автомашин, эргэлтийн хөрөнгө/-өө барьцаалуулан авах боломжтой зээл юм.

### Хөдөө аж ахуйн зээл

Эдийн засагт үзүүлэх Цар тахлын гамшгийн сөрөг нөлөөллийг бууруулж, эдийн засгийг идэвхжүүлэх зорилтын хүрээнд бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор жилийн 3%-ийн хүүтэй зээлийг Хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдэд олголоо.

### Шатахууны санхүүжилтийг дамжуулан зээлдүүлэх зээл

Гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтийг тогтоон барих, хомсдолоос сэргийлэх зорилгоор шатахуун импортлогч, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчдэд шатахууны нөөц бүрдүүлэх зорилгоор жилийн 3,0% хүүтэй зээл олголоо.

### Ханган нийлүүлэгчийн зээл

Аливаа байгууллагад бараа бүтээгдэхүүн нийлүүлдэг, ажил үйлчилгээ үзүүлдэг бизнес эрхлэгчдэд зориулан бизнесийн ашиг орлогоо нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагаагаа тасалдалгүй явуулахад нь дэмжлэг үзүүлэх зорилготой “Ханган нийлүүлэгчийн зээл”-ийн бүтээгдэхүүн.

### Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих зээл

Нийслэлийн жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих төвтэй хамтран ажиллаж Улаанбаатар хотын жижиг дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагад санхүүгийн дэмжлэг үзүүлэх зорилгоор жилийн 3,0% хүүтэй зээл олголоо.



### Орон сууцны борлуулалтыг дэмжих зээл

Ариг банкт хамтран ажиллах гэрээ байгуулсан барилгын төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж байгууллагаас борлуулж буй шинэ орон сууц болон төвийн шугамд холбогдсон шинэ амины орон сууц худалдан авах боломжтой онцгой бүтээгдэхүүн.

# ХАДГАЛАМЖ

## Байгууллагын хадгаламж

Харилцагч, түнш байгууллагуудтай таатай нөхцөлөөр хамтран ажиллаж, сул чөлөөтэй мөнгөн хөрөнгөө хадгаламжийн дансандаа байршуулан өндөр хүүтэйгээр өсгөх боломжтой хадгаламжийн бүтээгдэхүүн.

## Шаталсан хүүт хадгаламж

Орлого нэмэх тусам дансны үлдэгдлээс хамаарч хадгаламжийн хүү автоматаар өсөх нөхцөлтэй Шаталсан хүүт хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүн.

## Зарлага гаргах эрхтэй хугацаатай хадгаламж

Хадгаламжийн нөхцөлөө хэвээр хадгалан зарлага гаргаж, гэнэтийн санхүүгийн хэрэгцээгээ хангах боломжтой зарлага гаргах эрхтэй хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүн.

## Хуримтлалын Үндэс хадгаламж

Тогтмол хуримтлал үүсгэх дадал зуршлыг дэмжих зорилготой хуримтлалын үндэс хадгаламж. Сар бүр өөртөө тогтмол хуримтлалыг бий болгож чадсан харилцагчдыг жилийн 8,5 хувийн хүүгээр нэмж урамшуулна. Хадгаламжийн хамгийн өндөр хүүг санал болгож байна.

## Орон сууцны борлуулалтыг дэмжих хадгаламж

Барилгын компанийн орон сууцны борлуулалтыг дэмжих зорилготой орон сууцны борлуулалтыг дэмжих зээлийн бүтээгдэхүүнтэй хосолсон шинэ бүтээгдэхүүнийг гаргалаа.

Зээлдэгч үндсэн зээлээсээ төлбөр хийх бүрд тэр дүнгээр тухайн сардаа хадгаламжийн хүү хугацаа алдахгүйгээр зарлага гаргах эрхтэй.



# Эрсдэлийн удирдлага

## Эрсдэлийн удирдлагын бүтэц нь 4 түвшинд хуваагдана.

1 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Эрсдэлийн Удирдлагын Хороо /ТУЗ-н ЭУХ/: Эрсдэлийн удирдлагын баримтлах стратеги, бодлого болон банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинг батлах, тэдгээрийн хэрэгжилтийг хангуулах.

2 Банкны Эрсдэлийн Хороо /ЭХ/ нь банкны эрсдэлийн бодлого, үйл ажиллагаа нь банкны үндсэн үйл ажиллагаатай нийцэж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, түүний хэрэгжилтийг ТУЗ-ийн ЭУХ-д тайлагнах банкны гол эрсдэлүүдийг тодорхойлж, түүнийг бууруулах арга хэмжээг авах, эрсдэлийн удирдлагатай холбоотой журам зааврыг батлах, эрсдэлийн соёлыг нэвтрүүлэх, хөгжүүлэх, хэрэгжилтийг хянах үйл ажиллагааг хамаарна.

3 Эрсдэл хариуцсан нэгж болох Эрсдэлийн удирдлагын газар, Дотоод хяналтын газар. нь эрсдэлийн бодлого, журмын хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих, мөн банкны үйл ажиллагааг дэмжих болон удирдах нэгжүүд, бизнес нэгжүүдийн эрсдэлийн удирдлагад дэмжлэг үзүүлэх, эрсдэлийн удирдлагад оролцогчдыг холбох, эрсдэлийн нэгдсэн мэдээллээр хангах, банкны эрсдэлийн хорооны үйл ажиллагааг зохион байгуулах ажиллагааг хариуцна. 4 Салбар, тооцооны төв нь өөрсдийн хариуцан ажиллаж буй үйл ажиллагааны хүрээнд эрсдэлийг удирдаж ажиллана.

4 Салбар, тооцооны төв нь өөрсдийн хариуцан ажиллаж буй үйл ажиллагааны хүрээнд эрсдэлийг удирдаж ажиллана.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банк үйл ажиллагааны эрсдэлийн хүрээнд дараах эрсдэлээс сэргийлж ажиллана. Үүнд:

- Ашиглан,
- Залилан,
- Ажлын байрны аюулгүй байдлын эрсдэл,
- Харилцагчийн эрсдэл,
- Бүтээгдэхүүн үйлчилгээний эрсдэл,
- Мэдээлэл технологийн системийн эрсдэл,
- Дотоод үйл явцын эрсдэл,
- Гадаад хүчин зүйлийн эрсдэл,
- Хуулийн болон гадны зохицуулалтад үл нийцэх эрсдэл,
- Хариуцлагын эрсдэл,

- Хөрөнгийн эрсдэл,
- Боловсон хүчний эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь банкны үйл ажиллагааны эрсдэлийн түвшинг тодорхойлох, эрсдэлийг үүсгэж буй хүчин зүйлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх арга замын талаар шийдвэрүүдийг гаргаж гүйцэтгэлийг хэлэлцэн дүгнэж ажилладаг.

## ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРСДЭЛ

Эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа нь зээлийн эрсдэл, зах зээлийн эрсдэл, хөрвөх чадварын эрсдэл, үйл ажиллагааны эрсдэлийн үндсэн гурван чиглэлд тулгуурлан эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг хамгийн бага түвшинд байлгахад чиглэгдэж байна. Өнгөрөгч онд банкны

үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, хяналтын тогтолцооны оновчтой байдлыг үнэлэн, зөвлөмж боловсруулан холбогдох газар нэгжид хүргүүлэх замаар үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажилласан.

2021 онд гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийг хэрэгжүүлж, банкны мэдээллийн болон бүртгэлийн системд хандах хэрэглэгчийн эрхийн зохицуулалтыг шинэчлэн боловсруулж, хэрэглэгчийн зүй бус хандалт, хэрэглээнээс үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлж хүлээн зөвшөөрөх хамгийн бага түвшинд барьж ажиллалаа. Мэдээллийн аюулгүй байдлын хүрээнд бодлого журмыг шинэчлэн баталж мэдээллийн системийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангаж ажиллаж байна.

## ЗЭЭЛИЙН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

2021 онд Монголбанкнаас шинэчлэн баталсан "Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам"-тай холбогдуулан дотоод дүрэм, журамд шинэчлэлт хийж, үлдэгдэлтэй зээлийн ангиллыг өөрчилж, эрсдэлийн сан байгуулан Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг хангаж ажилласан. 2021 онд Ариг Банк нь зээлийн эрсдэлийн бодлогоо нарийвчлан тодорхойлж, эдийн засгийн нөхцөл байдал, банкны богино болон дунд хугацааны бизнес төлөвлөгөөтэй уялдуулан, зээлийн эрсдэлийн хязгааруудыг шинэчлэн өөрчилж, зээлийн эрсдэлээс сэргийлэх арга хэмжээг урьдчилан оновчтой хэрэгжүүлсэн. Банкны зээлийн эрсдэлийн удирдлагын гол зорилго нь гадаад хүчин зүйлсийн нөлөөгөөр зээлийн багцын чанар муудах мөн эдийн засгийн салбар, валют, зээлийн нэг бүтээгдэхүүнд эсвэл холбоотой бүлэг этгээдэд зээлийн хэт төвлөрөл бий болгохоос урьдчилан сэргийлэх, түүнчлэн банк эрх бүхий байгууллага болон хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ

биелүүлэхэд оршино. Энэхүү зорилгын хүрээнд бид зээлийн багцын чанарт үнэлгээ хийх, хүлээгдэж буй алдагдлын хэмжээг тодорхойлох, төвлөрлийн эрсдэлийг үнэлэх, хязгаарлах, нөхцөл байдлын шинжилгээ хийх зэргээр зээлийн багцын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна. Ариг Банк нь үр ашигтай эрсдэлийн удирдлагын гол үзүүлэлт болох эрсдэлийн хязгаарлалтуудыг банкны хэмжээнд, холбогдох нэгжүүдийн үйл ажиллагааны онцлог, цар хүрээг тооцоолон зохистой хэмжээнд боловсруулан баталж, хэрэгжүүлж ажилладаг. Ариг Банкны үйл ажиллагаа өргөжин тэлэхийн хэрээр зээлийг тухайн өдөрт нь бус цаг, минутын дотор шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх шаардлага нэмэгдсээр байна. Мөн зээлийн эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлэх үүднээс банкны салбар, тооцооны төвүүд, Зээлийн Хороо болон Төлөөлөн Удирдах Зөвлөл зэрэг зээл шийдвэрлэх түвшин болгонд зээлийн дээд хэмжээг тодорхойлж, зээлдэгчийн зээлжих чадварыг үнэлэн ажиллаж байна.



# Салбар нэгжийн мэдээлэл

Ариг банк нь Улаанбаатар хот болон Дархан хотод нийтдээ 12 салбар нэгж болон хувийн банкны төвөөрөө дамжуулан банкныхаа олон төрлийн үйлчилгээг харилцагчийн тав тух хангасан орчинд, тэдгээрийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хүргэж ажилласнаас гадна банкны зүгээс салбар нэгжүүдийнхээ өнгө төрх, тохижилтыг шат дараатайгаар шинэчилж ажиллаж байна.

Дээрх бодлогын хүрээнд, бүх төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг 365 хоногийн турш тасралтгүй, түргэн шуурхай хүргэх зорилгоор, Ариг банк нь Улаанбаатар хотын төв цэгт байрлах Улсын их дэлгүүрт салбараа нээн, Дөчин мянгат салбарынхаа өнгөр төрх, байршлыг сайжрууллаа.

Мөн Дархан-Уул аймаг дахь харилцагчиддаа зориулж, Дархан салбарынхаа үйлчилгээний танхимын зай талбайг нэмэгдүүлж, "Дархан зах" худалдааны төвд байршлыг шилжүүлэн, харилцагчдадаа ая тухтай, чанартай үйлчилгээ үзүүлэх орчныг сайжруулан ажиллалаа.


Ариг банк нь шинэ бизнес стратегийн хүрээнд харилцагч төвтэй үйлчилгээний шинэ стандарт, бизнес загварыг боловсруулж, Нийслэл болон орон нутагт хүн ам олноор төвлөрсөн байршилд шинэ салбар нэгжийн тоог нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн тэлэх бодлого баримтлан, нэгдсэн стандартын тохижилт бүхий ая тухтай орчинд банкны үйлчилгээг өндөр түвшинд хүргэж, харилцагчдынхаа сэтгэл ханамжийг нэмэгдүүлж ажиллахыг зорьж байна.




Ариг банкны Хувийн банкны төвийн мэргэшсэн ажилтнууд нь өндөр орлоготой, нэр хүндтэй иргэд, байгууллагуудад тэдний хэрэгцээ, таашаалд бүрэн нийцсэн санхүүгийн үйлчилгээг тав тухтай, найрсаг орчинд 24 цагийн турш тасралтгүй, орон зайг үл харгалзан хүргэж байна. Цаашид өсөн нэмэгдэж буй энэхүү үйлчилгээг харилцагчдад илүү ойртуулах, хөгжүүлэх чиглэлд бид зорин ажиллаж байна.

3 үгт хаяг

- Хан-Уул ТТ //явах.найдлага.малтмал
- Сонгинохайрхан ТТ //тэмүүлэл.онцлог.нүхлэх
- Баянзүрх ТТ //аялдаг.дайчлах.жишээлэх
- Хан-Уул Юнайтэд ТТ //давхцал.үйлдэх.найрамдал
- Хороолол Салбар //ариусах.өгүүлбэр.айзам
- 40Мянгат ТТ //далан.сүлжээ.улиас
- М20 ТТ //уянгалаг.жишээлэх.тансаг
- Бөмбөгөр ТТ //сондгой.түшиг.аргачлал
- Престиж ТТ //тэнхимд.арслан.чацуу
- Дархан Салбар //баясав.зууван.хэрэглээг
- Дархан Олон улс ТТ //алаглах.үдэлт.цонх
- Дархан Зах ТТ //нуур.тогоо.тогос





 [arigbank.mn](http://arigbank.mn) |  7013 3060 |  [arigbank](https://www.facebook.com/arigbank)

“Их Хуралдай” бизнес төв, 13/14 давхар  
Чингисийн өргөн чөлөө, 19-р хороолол, Хан-Уул дүүрэг,  
Улаанбаатар хот - 17030